

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГЭЭС НИЙСЛЭЛ ХОТОД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛААР ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ

2024.09.15

Багахангай дүүрэг

№	Актын нэр	Зүйл заалт	Нэмэлт оруулах санал	Өөрчлөлт оруулах санал
1	Монгол Улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай хууль	27 дугаар зүйл Газар өмчлөгч иргэний эрх, үүрэг	1.Нийслэлийн хэмжээнд цахимаар өмчилсөн иргэдийн газрыг өөрийн хүсэлтээр 1 удаа хүчингүй болгож өмчлөх эрхийг сэргээх	-
2	Газрын тухай хууль	40 дүгээр зүйл Газар эзэмших эрхийг гэрчилгээг хүчингүй болгох	1.Газрын цахим системд бүртгэгдэж албажсан хугацаанаас хойш 3 жил зориулалтын дагуу газраа ашиглаагүй тохиолдолд цахим системээс газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох	-
		60 дугаар зүйл Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх	1.Иргэн, хуулийн этгээд нь хуулийн байгууллагад төрийн албан хаагчийг гүжирдлэгийн чанартай худал мэдээлэл хүргэсэн нь хяналт шалгалтын явцад тогтоогдсон тохиолдолд тухайн иргэн, хуулийн этгээдийг холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэх	-
3	2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан “Нийгмийн халамжийн тухай хууль”	13.5.7. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	-	Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж өөрчлөн найруулах.
4	Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоол “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”	3.2. Иргэний нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж авах хүсэлтийг энэ журмын 3.1.1-3.1.3-т зааснаас гадна дараах баримт бичгийг үндэслэн шийдвэрлэнэ	3.2.8. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоосон тухай Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гэж нэмэлтээр оруулах.	-
5	Төрийн албаны тухай хууль	51.3.Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.	(үйлчилгээний албан хаагч) гэж нэмэлтээр оруулах.	-

6	Хорооны хэсгийн ахлагчийн ажиллах нийтлэг журам	1.4 хэсгийн ахлагч нь энэхүү журамд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ харьяа дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хорооны Засаг даргатай гурвалсан “Хөлсөөр ажиллах гэрээ” байгуулан ажиллана.	-	Гэрээт ажилтанг үндсэн ажилтан болгож өөрчлөх
7	Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 187 дугаар тогтоол	10 дугаар хавсралт Хорооны нийгмийн ажилтан: - Эрх зүй (0421), - Менежмент ба удирдахуй (041301-041303), - Нийгмийн шинжлэх ухаан (031), - Боловсролын шинжлэх ухаан (0111), - Багш, мэргэжлийн (0114), - Нийгмийн хамгаалал (092), - Эдийн засаг (0311)	-	Хорооны нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг мэргэжил харгалзахгүй болгож өөрчлөх
8	Галын аюулгүй байдлын тухай хууль, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм зэрэгт	Шинээр нэмж оруулах	Иргэд бага насны хүүхдийг хараа хяналтгүйгээр гэртээ үлдээхгүй байх талаар нэмэлт оруулах	-
9	Боловсролын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/	13.3 дугаар заалт. Багш ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана.	13.3.3.сүм, баг, тосгон, нийслэлийн алслагдсан дүүрэг дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;	-
10	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	11.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	11.2.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах; гэж заасан байдаг үүнийг сум дүүргийн ИТХ болон Засаг даргын хүрээнд өөрийн сум, дүүрэг орон	-

			нутагтаа зөвхөн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын чиглэлээр элс, хайрга, дайрга олборлох зөвшөөрөл өгч нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна гэж нэмэлтээр оруулах.	
11	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай	16.1.7.гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох; 16.1.8.паркийн удирдлага, нэгж үйлдвэрлэлийн ажилчдыг сургах, дадлагажуулах зорилгоор гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ үзүүлсэн бол ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх;	-	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.7, 16.1.8 дугаар заалтууд хэрэгждэггүй тул төрийн байгууллагын уялдаа холбоог ханган татварын тухай хууль, гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, гаалийн тухай хууль журмуудтай уялдуулах.
12	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	24.3.Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.	-	24.3. Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 15 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.
		29.2.Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.	29.3. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэж тухайн тендэрт 1-ээс дээш оролцогч байхгүй тохиолдолд гомдлын хугацааг мөрдөлгүй гэрээ байгуулж болно.	-
		47.2.Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна:	-	47.2.2.тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх ба уг процессыг баримтжуулна. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно
		55.3.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдлыг авч хэлэлцээд захиалагч энэ	55.3.4.Гомдол хянасан шийдвэр гарахаас өмнө шаардлагатай тохиолдолд захиалагч болон тендэрт оролцогч талуудаас албан бичгээр тайлбар өгөх боломж олгож болно гэж нэмэлтээр оруулах	-

		хуулийг зөрчсөн гэж үзвэл дараахь шийдвэр гаргана:		
13	Эрүүл мэндийн тухай хууль	29 дүгээр зүйл. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаа	29.5.Өрх, сум, тосгон, нийслэлийн алслагдсан дүүргийн эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг, алслагдсан 3 дүүрэг дэх төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.	-
14	Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам	5.10.8 байгууллагын баримт бичгийн эргэлтийн хэмжээ жилд 20,000 нэгжээс дээш бол бичиг хэргийн ажилтанд өөр ажил хавсруулахыг хориглоно.		5.10.8 Байгууллагын баримт бичгийн эргэлтийн хэмжээ жилд 40,000 нэгжээс дээш бол бичиг хэргийн ажилтанд өөр ажил хавсруулахыг хориглоно.

ТАНИЛЦСАН
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ХЯНАСАН
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

НЭГТГЭСЭН
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАГЫН ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР